



ТЕНДЕРИЙН УРИЛГА

2020 оны 1 дүгээр сарын 10–ны өдөр

G-9192-MON Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төсөл

G-01 дугаартай Хөдөө аж ахуйн трактор, тоног төхөөрөмж нийлүүлэх

1. Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яаманд Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү Ядуурлыг бууруулах Японы сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгийн тодорхой хэсгийг G-01 дугаартай Хөдөө аж ахуйн трактор, тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг санхүүжүүлэхэд зарцуулна.

2. Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам нь эрх бүхий тендерт оролцогчдоос:

50 морины хүчтэй трактор, анжис, роторт сийрүүлэгч, хүнсний ногооны үрлэгч, хураагчийн хамт тус бүр 4 ширхэг, Мотоблок түүний дагалдах тоног төхөөрөмж болох анжис, роторт сийрүүлэгч, хураагч, чиргүүлийн хамт тус бүр 20 ширхэгийг нийлүүлэх зорилгоор битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

3. Дотоодын өрсөлдөөнт тендер шалгаруулалтыг АХБ-ны нэг шаттай, нэг дугтуйт горимын дагуу явуулах бөгөөд тендерийн баримт бичигт заасны дагуу эрх бүхий орны харьяат нийт тендерт оролцогчдод нээлттэй байна.

4. Сонирхсон эрх бүхий тендерт оролцогч нь ажлын өдрүүдэд 9 цагаас 17 цагийн хооронд доорх хаягт хүрэлцэн ирж тендерийн баримт бичигтэй танилцаж болно.

5. Сонирхсон тендерт оролцогч нь доорх хаягт хандан бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50000** төгрөгийг Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 9192-MON төсөл хэрэгжүүлэх нэгжид хүлээлгэн өгсөнөөр тендерийн баримт бичгийг худалдан авч болно.

6. Тендерийн хамт тендерийн баталгааг төгрөгөөр ирүүлнэ. Цахим тендерийг хүлээн авахгүй. Хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахаас татгалзана. Тендерийг 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 15 цагаас 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 15 цаг 10 минутанд нээнэ.

7. Тендер бэлтгэх эсхүл хүргэхтэй холбоотойгоор тендерт оролцогчийн зүгээс гаргасан аливаа зардлыг Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яам болон төсөл хэрэгжүүлэх нэгж хариуцахгүй.

Захиалагчийн хаяг:

Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргааг сайжруулах 9192-MON төсөл

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 1-р хороо, Сайн констракшны байр, 3 давхар, 304 тоот, Харилцах албан тушаалтан: М.Ганпүрэв, Төслийн худалдан авах ажиллагааны мэргэжилтэн

Утас:+976 7012-9192